

МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН САЛБАР БА ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

*А.Буянтөгс**

Орчин үеийн нөхцөлд улс орон аль зэрэг глобальчлагдаж байгаагийн нэг гол үзүүлэлт нь гадаадын шууд хөрөнгө оруулалт ба түүний өсөлт юм.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь олон улсын эдийн засгийн гол хэлбэр болж, дэлхийн эдийн засаг дэлхийн зах зээлийн үеэс дэлхийн аж үйлдвэрлэлтийн шат руу шилжин орсныг нотолж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг голдуу үндэстэн дамнасан корпорацууд оруулдаг. Аж үйлдвэрийн зонхилох хэсгийг гадагшаа суурьшуулан компаний салбар байгуулж, нэг сүлжээнд холбогдсон бүтээгдэхүүний ба үйлчилгээний үйлдвэрлэлт бий болгож, олон үндэстний түүхий эд, ажиллах хүч ба өрсөлдөх чадвартай давуу талуудыг ашиглаж байна.

Дэлхийд одоогоор 63 мянган үндэстэн дамнасан корпорацын 800 мянган гадаадын салбар ажиллаж байна. Үүнээс 270 мянган салбар нь хөгжилтэй орнуудад, 360 мянган салбар нь хөгжиж байгаа орнуудад үлдсэн 170 мянган салбар нь шилжилтийн эдийн засагтай /хуучин социалист/ орнуудад байрладаг.¹

Үндэстэн дамнасан корпорац ба банкууд нь дэлхийн эдийн засгийн гол бүтэц, бүрэлдүүлэх хүчин зүйл болж байна. Үндэстэн дамнасан корпорацын гадаадын зах зээл дээр нэвтрэх гол давуу тал нь технологээр тэргүүлэх, шинэ технологи эзэмшсэн явдал юм. Иймээс уг корпорацуудын төсвийн зарцуулалтанд эрдэм шинжилгээний, туршилтын, зохион бүтээгчийн зардал ордог. Тиймээс ч шинжлэх ухаан техникийн дэвшилд үндэстэн дамнасан корпорац асар их нөлөө үзүүлж шинжлэх ухаан техникийн дэвшлийн гол чиглэлүүд, дэлхийн эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг тодорхойлж байна.

Үндэстэн дамнасан корпорацын эрдэм шинжилгээний төвүүд олон орнуудад байрладаг. Одоогоор Microsoft, Motorola, GM, GE, GVC, Samsung, ABM, Intel, Du Font, P&G, Ericsson, Nokia, Panasonic, Mitsubishi, AT&T, Siemens гээд Үндэстэн дамнасан корпорацын 100 гаруй эрдэм шинжилгээний төв ажиллаж байна.

Сүүлийн үед дэлхийн практикт шинэ үзэгдэл гарч, энэ нь хөгжиж байгаа орнуудаас тухайлбал шинээр үйлдвэржсэн орнууд Гонконг, Сингапур, Тайвань, Өмнөд Солонгос, Аргентин, Бразил, Малайзаас

*А.Буянтөгс – ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

хөрөнгийн экспорт /гадаадын шууд хөрөнгө оруулалт/ гаргах хандлага зонхилох боллоо.

Шинээр үйлдвэржсэн орнууд эрчимтэй хөгжиж өндөр хөгжилтэй орнуудын менежментийн зарчмыг сурч, шинэ технологи эзэмшин, эдийн засаг нь өндөр түвшинд хүрч, өөрийн гэсэн экспортын хөрөнгийн нөөцтэй болсон байна. Өнөөгийн байдлаар Шинээр үйлдвэржсэн дээрх орнууд ба Хятад улс хөрөнгө оруулагчдын зах зээл дээр гарч, хөрөнгийн нетто экспортлогч болов.

Монгол Улсад оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээгээр Хятад Улс нэгдүгээрт орж байна.

Гадаадын хөрөнгө оруулалт. /2000 оны 7 сар/

1. Хятад	23,4 %	
2. Япон	15,5 %	
3. Өмнөд Солонгос	9,9 %	
4. Америк	8,9 %	
5. Орос	5,1 %	
6. Гонгконг	4 %	
7. Англи	3,4 %	
8. Итали	2,8 %	
9. Тайвань	2,7 %	
10. Швецари	1,2 %	
11. Герман	0,9 %	
12. Бусад	19,1 %	

Эх сурвалж: Гадаадын хөрөнгө оруулалтын газрын материал.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт салбараар
/2000 оны 7 сар/

1. Уул уурхай	25
2. Хөнгөн үйлдвэр	20
3. Боловсруулсан түүхий эд	11
4. Худалдаа ба үйлчилгээ	6 ¹
5. Барилга	6 ¹
6. Банк санхүү	5 ¹
7. Холбоо	5 ¹
8. Бусад	22

Эх сурвалж: Гадаадын хөрөнгө оруулалтын газрын материал.

2000-2001 онд шинээр бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын 17 нь уул уурхай, 16 нь хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах, 12 нь хүнсний үйлдвэрлэл, 8 нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаагаа явуулж байна.

1990-2000 онд нэг компанид ногдох хөрөнгө оруулалт 0,24 сая ам. долл. байсан бол 2001 онд энэ үзүүлэлт 1,2 сая ам. доллар хүртэл өсчээ.²

Энэ өсөлт нь гол төлөв уул уурхай, газрын тосны салбарт том хөрөнгө оруулалт хийсэнтэй холбоотой. 1999-2001 онд орж ирсэн компаниудын 37% нь Хятадынх, 19% нь Солонгосынх, 13% нь Оросынх бөгөөд 6 % нь Японы компаниуд байлаа.

Өнөөдрийн байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалт уул уурхайн салбарт хамгийн их хэмжээгээр орсон бөгөөд энэ салбар нь манай экспортын орлогын 56,2% аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 53,2%-ийг бүрдүүлж байна. Уул уурхайн салбарт гадаад, дотоодын хамтарсан нийтдээ 220 компани үйл ажиллагаагаа явуулж байна. 2003 оны 4 дүгээр сарын байдлаар 2640 хайгуулын лицензи олгогдсон байгаа. Энэ нь манай улсын нийт газар нутгийн 25,95%-ийг эзэлж байна. Манай улс жилдээ 12 тонн алт, 125.2 мянган тонн зэс, 150 мянган тонн жонш, 5 сая тонн нүүрс олборлож байна. Зөвхөн 2002 онд алт олборлодог компаниуд Улсын төсөвт 14,967 тэрбум төгрөг оруулсан байна.

2002 оны байдлаар алт олборлолтоор тэргүүлж байгаа компаниуд:³

1. Золотой Восток-Монголия	2'	
2. Шижир алт ХХК	1'	
3. Монгол газар ХХК	7	
4. Гадурт ХХК	6	
5. Эрдэс холдинг ХХК	5	
6. Селигдор Монголия ХХК	4	
7. Эрэл ХХК	3	

Судалгаанаас үзэхэд, алт олборлолт нь алтны дэлхийн зах зээлийн үнэ, бизнесийн таатай орчин, алт олборлолттой холбоотой мэдээллийн ил тод байдлаас ихэд хамаардаг. Гадаадын хөрөнгө оруулагчдад алт олборлолтын салбарт хөрөнгө оруулах нь эрсдэл ихтэй байдаг ажээ. Монголын хувьд, усны нөөцийн дутагдал нь алт олборлолтыг хүндрүүлдэг гол нэг хүчин зүйл юм.

Сүүлийн жилүүдэд Канад улсын “Камеко”, “Айвенхоу Майнз” компаниуд Монголд идэвхитэй үйл ажиллагаагаа явуулж байна. “Камеко” компани нь Бороо алтны уурхайд 50 сая ам. долларын хөрөнгө оруулалт хийсэн. “Айвенхоу Майнз” компани бол Өмнөговь аймгийн Оюутолгойн алт зэсийн орд газрын хайгуулын ажил эрхэлж байна. Оюутолгойн орд нь урьдчилан тогтоосноор 700 тонн алт, 14 сая тонн зэсийн нөөцтэй бөгөөд дэлхийд 8 дугаарт орох орд юм.⁴ “Айвенхоу Майнз” компанийн эзэн Фридланд: “Оюу толгой төмрөөр цангасан Хятадын хаяанд байна. Тиймээс бид гол гарцынхаа хажууд

нь байгаа гэсэн үг” гэж “Файнэншел таймс” сонины 11 дүгээр сарын 12-ны дугаарт нийтлэгдсэн ярилцлагадаа⁵ тэмдэглэжээ. Мөн 2005 он гэхэд Оюу толгойн төслийн олборлолтын эхний бүтээгдэхүүн үйлдвэрлэгдэнэ гэжээ.

Уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдийг барьж байгуулах нь манай оронд ажлын байр нэмэгдүүлэх ба экспортыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм. Цаашид уул уурхайн салбар нь эдийн засгийн өсөлтөд чухал хувь нэмэр оруулах нь тодорхой юм. Одоогоор уул уурхайн салбарт шийдвэрлэх дөрвөн төсөл байгаа. Үүнд:

1. Эрдэнэтийн үйлдвэрийн зэсийн баяжуулах үйлдвэрийг шинээр барих төсөл
2. Өмнөговийн Таван толгойн нүүрсийг олборлох төсөл
3. Төмөртийн овооны төмрийн ордын төсөл
4. “Бүрэнхаан” фосфоритын ордын төсөл

Эдгээр төслүүдийн гадаадын хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэсэн нөхцөлд экспортын хэмжээ одоогийнхоос 4-6 дахин нэмэгдэх боломжтой ажээ.⁶

Тухайлбал, “Таван толгой” нүүрсний орд нь 20 жилийн өмнө нээгдсэн бөгөөд нөөц нь 5 сая тонн, баталгаатай нөөц нь 1,7 сая тонн гэсэн тооцоо судалгаа байдаг. Сүүлийн жилүүдэд Хятадад нүүрсний хэрэгцээ үлэмж хэмжээгээр өсч байгаагаас харахад ч “Таван толгойн” нүүрсний ордыг ашигласнаар тодорхой ашиг гарах боломж илэрхий байна. Жилд 3 сая тонн нүүрс боловсруулах хүчин чадалтай үйлдвэр байгуулснаар “Оюу толгойн орд”-ыг эрчим хүчээр хангаж, алт зэсийн олборлолтыг нэмэгдүүлж, улмаар экспортыг 2 дахин нэмэгдүүлэх боломжтой юм. “Төмөртийн овоо” ордын нөөц нь 230 сая тонн төмрийн хүдрийн нөөцтэй гэсэн судалгаа бий. “Төмөртийн овоо” ордыг ашиглаж Хятадад төмрийн хүдэр нийлүүлснээр Эрдэнэтийн үйлдвэрийн орлогоос дутахааргүй орлого олж болох юм. Одоогоор тус орд руу 100 км урт зам тавихаар төлөвлөж байгаатай холбоотой юм.

Гадаадын хөрөнгө оруулалтын ихэнх хувь нь Монголд жижиг болон дунд үйлдвэрүүдийг байгуулахад зориулагдсан байна. Энэ нь Монголын зах зээл жижиг, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд тээврийн зардал өндөр учраас үндэстэн дамнасан корпорациудаас оруулсан том хөрөнгө оруулалт одоогоор бага байна.

ИШЛЭЛ ЗҮҮЛТ

1. МЭ и МО. №2, 2003, х.43
2. Монгол Улс: үйлдвэр, худалдааны хөгжлийн бодлогын судалгаа. УБ, 2002, 11 дүгээр сар, х.77.
3. Монголия сегодня. №38/83/, 2003.09.20
4. Өнөөдөр №191 2003.08.15, Өнөөдөр 2003.04.02.
5. Өнөөдөр №277, 2003.11.26.
6. “Монголия сегодня” №39/84/, 2003.09.27.